



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 07

№ 05/11

Улаанбаатар хот

АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

СУМЫН  
ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.10, 18 дугаар зүйлийн 18.2, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн тус аймгийн Мандал сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагчдын дотуур байрын үйл ажиллагаанд 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтыг дотуур байрын нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, сургуулийн дотуур байрыг хариуцсан албан тушаалтан, ажилтнуудтай ярилцлага хийх, холбогдох тайлан мэдээ, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, хуулбарлан авах, баримтжуулах зэрэг аргачлалаар явуулсан болно.

Хяналт шалгалтаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Тус сургуулийн дотуур байр нь анх 1976 онд нийтийн байрын зориулалтаар баригдсан 1 давхар барилгыг 2017 онд 2 давхар болгож, гал тогооны хэсгийг шинээр өргөтгөж барьсан байна. Дотуур байр нь 100 хүүхдийн багтаамжтай, шалгалтын үед 36 сурагчтай байсан ба охидын 14, хөвгүүдийн 15 тасагт үйл ажиллагаа явуулж байв. Нэг тасагт 4 сурагч байхаар давхар 2 ортой бөгөөд орны банз элэгдэж, хугарсан, бичиг цаас хадгалах албан тасалгааны зориулалттай, тавиур, тасалгаагүй нимгэн төмөр шүүгээ өрөө тус бүрд 1 ширхгийг байршуулсан байх боловч хүүхэд бүрд хүрэлцээгүй, хувцас эд зүйлс хадгалах боломжгүй байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6781:2019 стандартын 5.3.5-т "Хүүхэд амьдрах өрөөнд хүүхдийн тоогоор ор, зөөлөн эдлэл байх бөгөөд хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон ширээ, сандал, хувцасны шүүгээ, хогийн савтай байна" гэж заасан шаардлагыг хангахгүй байна.
2. Мөн хүүхдийн бие засах өрөөний шаазан суултуур нь хүйтнээс хамгаалсан нэмэлт суултуургүй байгаа нь хүүхэд ашиглахад хүндрэлтэй цаашлаад шээсний замын цочмог үрэвсэлт өвчинд өртөх, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.
3. Гадны орчны тохижилт, гэрэлтүүлэг байхгүй, өрөөнүүдийн гэрэлтүүлэг муу, агааржуулалтын зохиомол системгүй, гал тогооны өрөөний хооллох танхим, хүүхэд амьдарч буй тасгууд дулаан алдагдалтай хүйтэн байгаа зэрэг нь Дотуур байрын орчин нөхцөл, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6781:2019 стандартын 5.1.2-т "сургуулийн болон дотуур байрын эзэмшил газрын 25 хувиас багагүй хэсгийг зүлэгжүүлж, мод тарьж цэцэрлэгжүүлнэ", 5.2.4-т "Байгалийн болон

150060027

зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй, аянга зайлуулагчтай байна” гэсэн заалтыг зөрчсөн.


4. Дотуур байрын гал тогооны хэсэг, давхар бүрд хяналтын 5 камер байрлуулсан байх боловч гадна орчинд хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс сэргийлэх, аюулгүй байдлыг хянах боломжит хяналтын камергүй байна. “Камерын шүүлтийг хянах” бүртгэлийн дэвтэртэй боловч хяналтын камерын бичлэгийг шалгах, хадгалах, түүнтэй танилцах журмыг батлан мөрдүүлээгүй нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/239 тоот тушаалын хавсралт Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмын 3.4.1-т “Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг хяналтын камертай болгон түүнийг ашиглах, бичлэг хадгалах, хянах дүрэм, журам батлан мөрдүүлнэ”, мөн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6781:2019 стандартын 9.10-т “Бичлэгийг ямар зорилгоор хэрхэн ашиглах талаар нэгдсэн журамтай” байх заалтыг хэрэгжүүлээгүй байна.
5. Сурагчдын хоолны илчлэг тогтоолгох, ундны уснаас дээж авч холбогдох байгууллагаар шинжлүүлж дүгнэлт гаргуулаагүй, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дугаар тушаал “Сургалт, хүмүүжлийн байгууллагад мөрдөх Эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн загвар” 6.10-т “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 900:2005 стандартын шаардлага хангасан унд, ахуйн халуун, хүйтэн усаар тасралтгүй хангагдсан байна”, 6.12-т “Зөөврийн болон хэсгийн усан хангамжтай байгууллага нь унд, ахуйн усандаа улирал тутам шинжилгээ хийлгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.
6. Дотуур байрын орчинд хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байдал, хүүхдийн сурч боловсрох, хөгжүүлэх, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажлын хөтөлбөр төлөвлөгөөгүй байсан нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн А/239 тоот тушаалын хавсралт Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6781:2019 стандартыг хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.

Иймд дээрх тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу дараах шаардлагыг хүргүүлж байна. Үүнд:

1. Дотуур байрын өрөөнүүдэд хувцас, эд зүйл хадгалах хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, зориулалтын шүүгээг хүүхэд бүрд олгох, хуучирсан ор, гудсыг шинэчлэх, түүнд зарцуулагдах төсвийн асуудлыг шийдвэрлэх;
2. Хүүхдүүдийн байрлаж буй өрөөний гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, дотуур байрын тасалгаа, нийтийн хэсгийн дулааныг нэмэгдүүлэх, хүйтний улиралд агаар сэлгэх зохиомол агааржуулалтын системийг шийдэх төсвийг шийдвэрлүүлэх;

3. Дотуур байрын гадаад орчны гэрэлтүүлэг, тохижилтыг хийж Дотуур байрын орчин нөхцөл, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6781:2019 стандартын 5.1.2-т заасныг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх;
4. Дотуур байрын гадаад орчинд хүүхдүүд гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрэлхэлт болон бие махбод, сэтгэл санааны дарамт хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс гадна хэсэгт хяналтын камерыг байрлуулах, бичлэгийг хадгалах, түүнтэй танилцах дүрэм журмыг батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
5. Хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, ундны усанд улирал тутам шинжилгээ хийлгэж хэвшүүлэх;
6. Сургууль, дотуур байрын багш ажилтнуудын хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг зөрчилд холбогдох эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллах, хяналтыг сайжруулах.

Шаардлагын мөрөөр авсан арга хэмжээний талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногт ирүүлнэ үү.

ГИШҮҮН  Д.СҮНЖИД